



**БОЛОВСРОЛЫН
ХҮРЭЭЛЭН**



Боловсролын хүрээлэнгийн захирлын
2019 оны 2 дүгээр сарын 26 өдрийн
тоот тушаалын хоёрдугаар хавсралт

**СУУРЬ БОЛОВСРОЛЫН МОНГОЛ ХЭЛ, ҮНДЭСНИЙ БИЧИГ, УРАН ЗОХИОЛ,
МАТЕМАТИК, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ, ФИЗИК БИОЛОГИ, ХИМИ, ГАЗАР ЗҮЙ,
ТҮҮХ, НИЙГЭМ СУДЛАЛ, ДҮРСЛЭХ УРЛАГ, ХӨГЖИМ, ДИЗАЙН, ТЕХНОЛОГИ,
БИЕИЙН ТАМИР, АНГЛИ ХЭЛ, ОРОС ХЭЛНИЙ СУРГАЛТЫН САЙЖРУУЛСАН
ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ СУРАЛЦАХУЙН УДИРДАМЖ**

(Суурь боловсрол VI-IX анги)

Улаанбаатар
2019



**БОЛОВСРОЛЫН
ХҮРЭЭЛЭН**

**ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ДҮРСЛЭХ
УРЛАГИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
СУРАЛЦАХУЙН УДИРДАМЖ**
(Суурь боловсрол YI-VIII анги)

Улаанбаатар
2019

“Дүрслэх урлаг”-ийн сургалтын цөм хөтөлбөр (2015)

Багийн ахлагч:

Сүх-Очирын Батцоож, магистр МУБИС-ийн ДУТС-ийн багш

Багийн гишүүд:

Дашзэвэгийн Цэдэн-Иш Ph.D, дэд профессор МУБИС-ийн БС-ийн багш

Загджавын Баярмагнай, Ph.D, дэд профессор МУБИС-ийн БС-ийн багш

Адьяагийн Ариунболд, Ph.D, дэд профессор МУБИС-ийн ДУТС-ийн багш

Сургалтын цөм хөтөлбөрийг сайжруулсан ажлын хэсэг: (2019)

Адьяагийн Ариунболд, Ph.D, дэд профессор МУБИС-ийн ДУТС-ийн тэнхимийн эрхлэгч

Доржийн Хөхөө, Ph.D, дэд профессор МУБИС-ийн ДУТС-ийн зөвлөх багш

Пүрэв Болдбаатар, БГД-ийн 20 дугаар сургуулийн багш

Хянан тохиолдуулсан: (2019)

Сияатовын Отгонтуяа, магистр, Боловсролын хүрээлэн, БХСС-ийн ЭША

ТАНИЛЦУУЛГА

Урлагийн сургалтын хөтөлбөр нь: Урлаг хичээлээр суралцагчдын эзэмших мэдлэг, чадвар, суурь боловсрол эзэмшсэнээр хүрэх үр дүнг тодорхойлсон.

Сургалтын хөтөлбөрийн агуулгын шинэчлэлийн хэрэгцээ:

Сургалтын зорилгын үндсэн дээр ЕБС-ийн урлагийн хичээлээр урлагийг мэдэрч, бүтээлч сэтгэлгээгээр илэрхийлж, таашаан мэдэх чадварыг хөгжүүлэх болон урлаг, соёлын талаарх ойлголтыг гүнзгийрүүлж, гоо зүйн баялаг мэдрэмжтэй хүн болгон төлөвшүүлэхийг зорьж дараах арга замуудыг тодорхойлж байна. Үүнд: “Урлагийн хэл”, “Урлан бүтээхүй”, “Бүтээлч илэрхийлэл”-ээр агуулгын хүрээг тодорхойлсон.

(а) “Дүрслэх урлагийн хэл”-ийн тухайд урлагийн бүтээлийг бүтээж буй (хэрэгслүүдийг) хэрэглүүрүүдийг танин мэдэж, эдгээр үйл ажиллагаанаас гарах онцлог шинжийг мэдэрч, дүрслэлийн хэл, нэр томъёог үйл ажиллагаатай холбон ойлгох явдлыг бодитоор тодорхойлох.

(б) “Урлан бүтээхүй”-н тухайд сурагчид дүрслэлийн цэг, толбо, зураас, дүрс, өнгө болон хөгжмийн эгшгүүд хэрхэн холбогдож байгааг туршиж үзэх, таталбар, судалбар хийхийнбүтээл хийх, тэдгээрийг нэгтгэн хөгжим зохиох зэргээр үйл явцыг өөрийн биеэр хийх нь чухал. Мөн өөрийгөө илэрхийлэх чадварыг төсөөлөх, ургуулан бодох чадвартай хослуулан уг чадваруудаа дэс дараалалтайгаар, хэрхэн яаж илэрхийлэхийг анхаарах.

(в) “Бүтээлч илэрхийлэл”-ийн хүрээнд урлагийн талаарх үг хэллэг ашиглан, сурагч ул суурьтайгаар өөрийн хэмжээнд шүүмжлэх чадварыг хөгжүүлэх. Эргэн тойрон дахь хүрээлэн буй орчин, байгаль, юмс, үзэгдэл, урлагийн бүтээлийн сайхныг мэдэрч, өөрийнхөөрөө баяжуулж зохиох, найруулах, бүтээж сурахад заах аргыг чиглүүлэх.

(г) Өөрийн орны болон бусад улс орнуудын , урлаг, соёлоос суралцаж хэрхэн илэрхийлж байгааг мэдэрч, тухайн орны уран бүтээлчдийн бүтээл туурвилыг үзэж танилцан, өөрийн мэдрэмжийг баяжуулах зэргээр залгамж холбоог мэдрэх, сонирхлыг нэмэгдүүлэх арга зүйг сонгоно.

Суралцахуйн удирдамж нь: Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүйн хувилбарыг зөвлөмжилсөн.

Суралцахуйн зорилтууд нь хичээлээр эзэмших чадваруудыг тодорхойлсон.

- Суралцахуйн зорилт нь анги бүрт тодорхой, суралцагч бүрийн чадваржсан мэдлэгээр хэмжигдэхүйц байхад анхаарсан.
- Суралцагч бүрийн суралцах хэрэгцээ, сонирхолд нийцсэн сонголтот, уян хатан, нээлттэй агуулгыг боловсролын түвшин бүрд ахисан байхаар сонгосон.
- Агуулга нь хам сэдвээр багцлагдсан суралцахуйн зорилтуудаар тодорхойлогдсон.

Тухайн хичээлийн арга зүй нь үйлийн явцад суралцах арга барилд суурилан зохион байгуулагдах ба сурагчдын мэдлэг бүтээхүйд дэмжлэг болсон, хөгжүүлэх, чадваржуулахад чиглэсэн.

ДҮРСЛЭХ УРЛАГ

2. АГУУЛГА

2.1. VI АНГИ

6.1 ДҮРСЛЭХ УРЛАГИЙН ХЭЛ

- 6.1а. Уламжлалт болон улс үндэстний өнгийн бэлгэдлийг харьцуулах
- 6.1б. Өнгийн дагнаас, зохицол, эрс тэс чанарыг урлагийн бүтээлийн жишээ гарган тайлбарлах
- 6.1в. Шулуун тахир нуман зураасны онцлогийг танин мэдэж тосон харандаа усан будаг ашиглан зураасны чөлөөт зохиомж хийн турших
- 6.1г. Юмсын хол, ойр байршил ба биетийн эзэлхүүнийг нэг цэгийн алслалтын аргаар дүрслэн харуулах
- 6.1д. Биеийн ерөнхий хэмжээ, харьцааг баримжаалан дүрслэх аргаар амьтан зурах

6.2 УРЛАН БҮТЭЭХ

- 6.2а. Уран сайхны үсгийн хэлбэр, онцлогийг таньж тодорхойлох
- 6.2б. Өөрийн бодол төсөөллийг шог хошин зургийн аргаар илэрхийлэх
- 6.2в. Өөрийн бодол төсөөллөө уран зургийн аргаар илэрхийлэх
- 6.2г. Цоолборлох аргаар амьтны дүрсийн гаралтай хээ, угалзыг давтамжтайгаар дүрслэх

6.3 СОЁЛЫН ҮНЭТ ЗҮЙЛ

- 6.3а. Ардын гар урлалын төрлүүдийг бүтээлийн жишээн дээр тайлбарлах
- 6.3б. Хүй нэгдлийн үеэс -XIV зууны үеийг хүртлэх монголын дүрслэх урлагийн зарим бүтээлийг таньж тодорхойлох
- 6.3в. Дэлхийн эртний улсуудын дүрслэх урлагийн зарим бүтээлийг таньж тодорхойлох

2.2. VII АНГИ

7.1 ДҮРСЛЭХ УРЛАГИЙН ХЭЛ

- 7.1а. Ахромат, хромат өнгө, өнгийн тон, ханалт, хоршил, харшил зонхилох өнгийг ялгах
- 7.1б. Тосон харандааны хүнд хөнгөн даралтыг нягт сийрэг байдлаар зурааслах
- 7.1в. Юмсын хол, ойр байршил ба биетийн эзэлхүүнийг хоёр цэгийн алслалтын болон урвуу алслалтын аргаар дүрслэх
- 7.1в. Биет өөрийн болон биет хоорондын хэмжээ, харьцааг жишиж харьцуулах аргыг зураг дүрслэлдээ ашиглах

7.2 УРЛАН БҮТЭЭХ

- 7.2а. Геометр биетийн гэрэл, сүүдрийг зурааслах аргаар илэрхийлэх
- 7.2б. Гротеск төрлийн үсгийг хэв ашиглан бичих, бичлэгийн онцлогийг тайлбарлах
- 7.2в. Таталбар, судалбар зургийн аргаар хүн ба амьтныг дүрслэх
- 7.2г. Байгалийн өнгө төрх, үзэгдлийг судалбар зургийн аргаар өнгөөр дүрслэх
- 7.2д. Ардын зураг ба шүтээн зургийн ялгаа, онцлогийг таньж тодорхойлох
- 7.2е. Монгол зургийн зурааслах техникүүдийг зураг дүрслэлд ашиглах

7.3 СОЁЛЫН ҮНЭТ ЗҮЙЛ

- 7.3а. Зүмбэрлэх болон шуумал хийх аргыг туршин хэрэглэх

- 7.3б. XIV-XVII зууны үеийн Монголын дүрслэх урлагийн зарим бүтээлийг таньж тодорхойлох
- 7.3в. Дундад зууны болон дэлхийн зарим улс үндэстний дүрслэх урлагийн зарим бүтээлийн онцлогийг таньж тодорхойлох

2.3. VIII АНГИ

8.1 ДҮРСЛЭХ УРЛАГИЙН ХЭЛ

- 8.1а. Дулаан, хүйтэн, ойролцоо өнгийн зохицол үүсгэн зохиомжлох, зураг дүрслэлд хэрхэн нөлөөлөхийг ашиглах
- 8.1б. Цэг, толбо зураасыг хослуулан хүн амьтан, эд юмсыг чөлөөт зохиомжоор дүрслэх
- 8.1в. Юмсын хол, ойр байршил ба биетийн эзэлхүүнийг хоёр ба гурван цэгийн алслалтын аргаар дүрслэн харуулах
- 8.1г. Хүүхэд болон том хүнийг зурахдаа хүний биеийн ерөнхий харьцааг дүрслэх аргыг ашиглах

8.2 УРЛАН БҮТЭЭХ

- 8.2а. Натюрмортын гэрэл,сүүдрийг зурааслах аргаар илэрхийлэх
- 8.2б. Антиква үсгийн уран бичлэгийн онцлогийг тайлбарлах
- 8.2в. Өөрийн бодол төсөөллийг бар зургийн аргаар илэрхийлэх
- 8.2г. Натюрмортын гэрэл,сүүдрийг өнгөөр илэрхийлэх
- 8.2д. Монгол зургийн зохиомж, өнгө, арга ажиллагаа уран бүтээлийн жишээн дээр тайлбарлах
- 8.2е. Монгол зургийн аргаар өгөгдсөн сэдвээр бүтээл хийх

8.3 СОЁЛЫН ҮНЭТ ЗҮЙЛ

- 8.3а. Монголын дүрслэх урлагийн төлөөлөгчдийн бүтээлийг таньж тодорхойлох /1921 оноос өнөөг хүртлэх үе/
- 8.3б. Сэргэн мандалтын үеийн дүрслэх урлагийн зарим бүтээлийг таньж тодорхойлох
- 8.3в. Дүрслэх урлагийн зарим чиг хандлагуудыг бүтээлийн жишээн тайлбарлах

ЗУРГААДУГААР АНГИЙН ДҮРСЛЭХ УРЛАГИЙН СУРАЛЦАХУЙН УДИРДАМЖ

6.1 Дүрслэх урлагийн хэл

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
6.1а. Уламжлалт болон улс үндэстний өнгийн бэлгэдлийг харьцуулах	<ul style="list-style-type: none"> - Уламжлалт болон улс үндэстний өнгийн бэлгэдлийг талаар уншиж судлах, ярилцана. - Улс үндэстнүүдийн зураг бүтээлийн жишээн дээр өнгийн бэлгэдлийн талаарх ойлголтоо илэрхийлнэ. Улс үндэстнүүдийн өнгийн бэлгэдлийг харьцуулан тайлбарлах, бэлгэдлийн учир холбогдлыг талаарх өөрийн бодлоо илэрхийлнэ. - Сэдэвт зураг зурна. - Зургийн өнгийг сонгохдоо бэлгэдлийн утгыг шингээх - Зураг бүтээлээ тайлбарлах <p><i>Багшийн анхаарах зүйл: Монголчууд бүтээл хийхдээ бэлгэдлийг чухалчлан үздэгийг анхааруулах хэрэгтэй юм. Сурах бичиг ашиглахаас гадна багш сурагчдын түвшинд тохирсон зурах, бүтээх, харьцуулан жиших, хувиргах, уншаад зурах, гүйцээж зурах, зураг уншаад бүтээх, будах, наах, зэрэг дасгал даалгавар боловсруулан ажиллуулж болно.</i></p>	Зурагт үзүүлэн, бүтээлүүд О, Нацагдорж нар. Дүрслэх урлаг, VI-VII ангийн сурах бичиг. УБ., 2017 он. Хуудас 26-27
6.1б. Өнгийн дагнаас, зохицол, эрс тэс чанарыг урлагийн бүтээлийн жишээ гарган тайлбарлах	<p><i>Үйл ажиллагаа 1.</i></p> <ul style="list-style-type: none"> - Монгол хээ угалз зурах. /Хээ угалзыг зурахдаа дагнааслах аргыг ашиглана/ - Өнгийг цайруулах болон гүнтүүлэх аргаар түйхий дагнаас хийх, дулаан, хүйтэн өнгөөр дагнан будах туршилт хийнэ. - Байгалийн гаралтай хээ, угалз ашиглан өнгөөр дагнааслах аргаар сэдэвт зураг зурна. - Өнгийн дагнаасын талаарх ойлголтоо өөрийн бүтээлийн жишээгээр дээр тайлбарлан ярилцана. <p><i>Үйл ажиллагаа 2.</i></p> <ul style="list-style-type: none"> - Хүйтэн, дулаан өнгийн зохицлыг зураачдын бүтээлээс ажиглах, өнгийн хоршил, харшилыг талаарх ойлголтоо зураг дүрслэлдээ ашиглан зурах - Өнгийн зохицол, эрс тэс чанарыг хүүхдийн болон зураачдын бүтээлийн жишээн дээр тайлбарлах <p><i>Багшийн анхаарах зүйл: Зураг бүтээлийг сонгохдоо өнгийн дагнаас, зохицол, эрс тэс чанарыг илэрхийлэмж тод харагдахуйц бүтээл байхыг анхаараарай.</i></p>	Зурагт үзүүлэн, өнгийн цаас, өнгийн дугуй, хүүхдийн бүтээлүүд О, Нацагдорж нар. Дүрслэх урлаг, VI-VII ангийн сурах бичиг. УБ., 2017 он. Хуудас 28-35
6.1в. Шулуун тахир нуман зураасны онцлогийг танин мэдэж тосон харандаа усан будаг ашиглан зураасны чөлөөт зохиомж хийн турших	<ul style="list-style-type: none"> - Харандаа, бийр, эсгий бал, тосон харандаагаар шулуун, тахир, нуман, долгион зураасны олон төрлүүдийг зурааслан турших - Тосон харандаагаар хээ угалз зурах - Зураасны олон төрөл, шинж чанарыг сэдэвт зургийн үйл явдал, дүр дүрслэлтэй уялдуулан зөв сонгон зурах - Өөрийн болон бусдын бүтээлд ажиглалт хийж зураасны ялгааны талаар ярилцах - Зураасны чөлөөт зохиомжийн санаа гаргах, чимэглэлд хэрэглэх <p><i>Багшийн анхаарах зүйл: Тосон харандаа, усан будгаар зураасны чөлөөт зохиомжийг харуулсан санаа өгөхүйц үзүүлэн бэлтгэсэн байна.</i></p>	Өнгийн тосон харандаа, зургийн дэвтэр, эсгий бал, бийр, усан будаг О, Нацагдорж нар. Дүрслэх урлаг, VI-VII ангийн сурах бичиг. УБ., 2017 он. Хуудас 14-17
6.1г. Юмсын хол, ойр байршил ба биетийн зээлхүүнийг хоёр цэгийн	<ul style="list-style-type: none"> - Нэг цэгийн алслалтаар машин зам, төмөр зам, шонгын мод зурах - Ажиглагчийн байршлаас хамааран харааны түвшин 	Сурах бичиг, өнгийн харандаа, зургийн дэвтэр, эсгий бал,

алслалтын аргаар дүрслэн харуулах	хэрхэн өөрчлөгдөж буйг ажиглах - Зургийн хавтгай дээр харааны түвшин татаж, нэг цэгийн алслалтын шугаман байгуулалт хийж зам зурах - Өнгийн хүйтэн, дулаан шинж болон хүнд хөнгөний ялгаагаар орон зайг илэрхийлэн зурах -Өнгийн харандаа, усан будгаар будах	бийр, усан будаг О, Нацагдорж нар. Дүрслэх урлаг, VI-VII ангийн сурах бичиг. УБ., 2017 он. Хуудас 92-95
6.1д. Биеийн ерөнхий хэмжээ, харьцааг баримжаалан дүрслэх аргаар амьтан зурах	- Эх ба төл мал зурахдаа биеийн хэмжээ, харьцааг баримжаалан зурах - Мал амьтны толгой ба биеийн хэмжээ, харьцааг ажиглан ярилцах - Сэдэвт зураг зурахдаа том жижиг амьтдын хэмжээ, харьцааг зөв баримжаалан зурах -Зураг бүтээлээ баяжуулан зурах, будах -Бүтээлийн санааг тайлбарлан ярилцах <i>Багшийн анхаарах зүйл: Биеийн ерөнхий хэмжээ, харьцааг хэрхэн баримжаалан дүрслэх талаар багш сурагчдад зааварчилгаа өгсөн байна.</i>	Харандаа, зургийн дэвтэр, балын харандаа бийр, усан будаг

6.2 Урлан бүтээх

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
6.2а. Уран сайхны үсгийн хэлбэр, онцлогийг таньж тодорхойлох	- Энгийн болон уран сайхны үсгийн ялгаатай талуудын талаар ярилцах - Уран сайхны үсгийн хэлбэр, онцлогийг өөрийн бодлоор тайлбарлах -Үгийг тухайн үгийн утга санаатай уялдуулан зохиомжлон зурах -Үсгийг хээгээр чимэглэх, хэлбэр дүрсийг нь өөрчлөн зурах <i>Багшийн анхаарах зүйл: Сурагчдын сонирхол, оролцоо идэвхийг дэмжих нь чухал. Тухайлбал, Аливаа зураг бүтээлийг сонирхон харах, ажиглах, өөрийн сэтгэгдлээс урган гарсан мэдрэмж санаагаа илэрхийлэх, бусадтайгаа хуваалцах үйл ажиллагааг төлөвлөж, хэрэгжүүлэх нь зүйтэй.</i>	Харандаа, зургийн дэвтэр, балын харандаа өнгийн харандаа О, Нацагдорж нар. Дүрслэх урлаг, VI-VII ангийн сурах бичиг. УБ., 2017 он. Хуудас 9
6.2б. Өөрийн бодол төсөөллийг шог хошин зургийн аргаар илэрхийлэх	- Шог хошин зургууд үзэх, үйл явдал, утга санаа, зурах арга илэрхийллийн онцлогын талаар ярилцах - Хүүхдийн зурсан хошин, шог зургуудтай танилцах, зургийн утга санаа, илэрхийлэмжийг тайлбарлан ярилцах - Шог хошин зургийн санаа гаргах - Санаагаа зураг дүрслэлээр илэрхийлэн зурах - Бусдынхаа зурсан хошин, шог зургийн утга санааг тайлбарлах - Өөрийн зурсан зургийн утга санаагаа тайлбарлахдаа шог зургийн ойлголтоо илэрхийлэх	Харандаа, зургийн дэвтэр, балын харандаа О, Нацагдорж нар. Дүрслэх урлаг, VI-VII ангийн сурах бичиг. УБ., 2017 он. Хуудас 10-13
6.2в. Өөрийн бодол төсөөллөө уран зургийн аргаар илэрхийлэх	- Сонгосон уран зургийн бүтээл үзэх, тухайн бүтээлээс төрсөн сэтгэгдлээ ярилцах -Уран зургийн өнгө дүрслэлийн онцлогийг хар зургийн бүтээлтэй харьцуулан ажиглах - Байгалийн зураг өнгөөр зурах, сэдэвт зураг зурах	Харандаа, зургийн дэвтэр, балын харандаа бийр, усан будаг
6.2г. Цоолборлох аргаар амьтны дүрсийн гаралтай хээ, угалзыг давтамжтайгаар дүрслэх	- Хамар угалзан хээг цоолборлох аргаар давтамж үүсгэн зурах -Хээ угалзыг давтамжтайгаар зурах, нэг хээг олшруулах бусад аргын тухай ярилцах,	Харандаа, зургийн дэвтэр, балын харандаа бийр, усан будаг

	<ul style="list-style-type: none"> -Тор татаж зурах аргаар хээ зурах. - Хээ угалзыг ахуй амьдралд хэрэглэх - Хээний бэлгэдэл утга агуулгатай уялдуулан сонгох тухай ярилцах 	О, Нацагдорж нар. Дүрслэх урлаг, VI-VII ангийн сурах бичиг. УБ., 2017 он. Хуудас 40
--	--	---

6.3 Соёлын үнэт зүйл

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
6.3а. Ардын гар урлалын төрлүүдийг бүтээлийн жишээн дээр тайлбарлах	<ul style="list-style-type: none"> - Ардын гар урлалын бүтээл, төрлүүдийн талаар судлах - Ардын гар урлалын төрлүүд түүний төлөөлөл болсон бүтээлүүдийг ажиглах - Оёдол хатгамал, уран сийлбэр, дархан, эсгий урлал, арьсан урлал, шуумал, зүмбэрийн урлагийн бүтээлийн онцлог, ялгаа, бүтээх арга ажиллагааны талаар зураг бүтээлийн жишээгээр тайлбарлах - Ардын гар урлал бүтээлүүдийн талаарх өөрт төрсөн сэтгэгдлээ илэрхийлэх 	Бодит болон зурагт үзүүлэн О, Нацагдорж нар. Дүрслэх урлаг, VI-VII ангийн сурах бичиг. УБ., 2017 он. Хуудас 41
6.3б. Хүй нэгдлийн үеэс - XIV зууны үеийг хүртлэх Монголын дүрслэх урлагийн зарим бүтээлийг таньж тодорхойлох	<ul style="list-style-type: none"> - Хадны сүг зураг, хүрэл зэвсгийн үеийн эд зүйлс, бугат болон хүн чулуун хөшөөний талаар уншиж судлах - Хүй нэгдлийн болон өвөг Монголчуудын зураг дүрслэлийн ялгааг харьцуулан тайлбарлах, онцлогийг тодорхойлох -Уйгарын үеийн ханын зураг их Монгол улсын хаадын хөрөг, Чингисийн чулууны бичээс зэргийг харж ажиглах - Бүтээлийн онцлогийг харьцуулж өөрт төрсөн сэтгэгдлээр тайлбарлах - Өөрт төрсөн сэтгэгдлээ баримтат мэдээлэл, түүхэн цаг хугацаа, дүрслэлийн онцлогтой холбон дүгнэлт хийн ярилцах 	Зурагт үзүүлэн, түүхэн эх сурвалж О, Нацагдорж нар. Дүрслэх урлаг, VI-VII ангийн сурах бичиг. УБ., 2017 он. Хуудас 54-59
6.3в. Дэлхийн эртний улсуудын дүрслэх урлагийн зарим бүтээлийг таньж тодорхойлох	<ul style="list-style-type: none"> - Ертөнцийн долоон гайхамшиг болон эртний Египет, Грек, Ромын урлагийн бүтээлүүдтэдгээрийн онцлог, хийц, загварын талаар түүхэн цаг үетэй холбон ярилцах - Түүхэн цаг үе тухайн үеийнхээ урлагийн бүтээлд хэрхэн тусгалаа олж илэрхийлэгдсэн эсэх талаар хэлэлцүүлэг өрнүүлэх ярилцах, өөрийн ойлголтоо илэрхийлэх 	Зурагт үзүүлэн, О, Нацагдорж нар. Дүрслэх урлаг, VI-VII ангийн сурах бичиг. УБ., 2017 он. Хуудас 62-63

ДОЛООДУГААР АНГИЙН ДҮРСЛЭХ УРЛАГИЙН СУРАЛЦАХУЙН УДИРДАМЖ

7.1 Урлагийн хэл

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
7.1а. Ахромат, хромат өнгө, өнгийн тон, ханалт, хоршил, харшил зонхилох өнгийг ялгах	<ul style="list-style-type: none"> Өнгийн дугуй, өнгийн гэрэлтэлт, ханалтыг харуулсан зурагт үзүүлэн дээр ажиглалт хийж нэг өнгийн дагнаас, хувиралын талаар ярилцах -Сэтгэгдлээ илэрхийлэх - Хар цагаан өнгийн ялгарлаар амьтан, ургамал зурах. - Усан будгаар уусгаж зурах аргаар өнгийн шилжилт хийн байгалийн зураг зурах 	Харандаа, зургийн дэвтэр, балын харандаа бийр, усан будаг О, Нацагдорж нар. Дүрслэх урлаг, VI-VII ангийн сурах бичиг. УБ., 2017 он. Хуудас 88-90

7.1б. Тосон харандааны хүнд хөнгөн даралтыг нягт сийрэг байдлаар зурааслах	-Тосон харандааг усан будагтай хослуулан зурах аргаар сэдэвт зураг зурах. -Тосон харандаан зураасан дээр усан будаг тогтохгүй чанарыг ашиглан зураг зурах туршилтууд хийх - Туршилтын үр дүнгийн талаар ярилцах	Тосон харандаа, усан будаг, усан будгийн цаас, бийр О, Нацагдорж нар. Дүрслэх урлаг, VI-VII ангийн сурах бичиг. УБ., 2017 он. Хуудас 78-79
7.1в. Юмсын хол, ойр байршил ба биетийн эзэлхүүнийг хоёр цэгийн алслалтын болон урвуу алслалтын аргаар дүрслэн харуулах	- Хоёр цэгийн алслалтаар шоо, энгийн хийцтэй байшин зурах. - Хоёр цэгийн байршлаас шалтгаан биетийн хэлбэр дүрс хэрхэн өөрчлөгдөж байгааг ажиглах - Төрөл бүрийн эд зүйлсийг хоёр цэгийн алслалтын шугаман байгуулалтаар зурсан дүрслэлийн талаар ярилцах - Урвуу алслалтаар дүрсэлсэн зураг бүтээлүүдийг ажиглан дүрсийн алслалт, урвуу алслалтын ялгааг ярилцах - Урвуу алслалтаар зураг зурах, урвуу алслалтын талаарх ойлголтоо өөрийн зурсан зургийн жишээн дээр тайлбарлах	Балын харандаа, зургийн дэвтэр шугам, баллуур, үзүүлэн О, Нацагдорж нар. Дүрслэх урлаг, VI-VII ангийн сурах бичиг. УБ., 2017 он. Хуудас 96-97
7.1г. Биет өөрийн болон биет хоорондын хэмжээ, харьцааг жишиж харьцуулах аргыг зураг дүрслэлдээ ашиглах	- Геометрийн энгийн дүрс, сав суулга, жимс зэргийн хэмжээ харьцааг ажиглан баримжаалан хуулж зурах - Натюрморт зурсан сургалтын зураг, уран бүтээлд ажиглалт хийж юмсын байршил, хэмжээ харьцааг дүрсэлсэн байдлыг хуулбарлан зурах -Биет болон биетүүдийн хоорондын хэмжээ, харьцааг жишиж харьцуулах аргаар зурах, дүрслэх - Зурж, дүрслэх явцад асуудал гарсан эсэх түүнийг хэрхэн шийдвэрлэсэн талаараа ярилцах	Үзүүлэн, зургийн дэвтэр, балын харандаа, баллуур

7.2 Урлан бүтээх

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
7.2а. Геометр биетийн гэрэл,сүүдрийг зурааслах аргаар илэрхийлэх	- Шоо болон бөмбөрцөгийн гэрэл сүүдрийг бодит байдлаас болон зурагнаас хуулбарлан зурахдаа гэрэл сүүдрийг зурааслах -Дэвсгэртэд зурагдах зүйлсийн (шоо болон бөмбөрцөг) ерөнхий овор хэмжээг тогтоох - Биет тус бүрийн байршил харьцааг тогтоох, нэг бүрчлэн хэлбэрийг гаргах - Зурааслах аргаар гэрэл сүүдрийн хүнд хөнгөн ялгаатай байдлыг илэрхийлэх	Үзүүлэн, зургийн дэвтэр, балын харандаа, баллуур О, Нацагдорж нар. Дүрслэх урлаг, VI-VII ангийн сурах бичиг. УБ., 2017 он. Хуудас 98-101
7.2б. Гротеск төрлийн үсгийг хэв ашиглан бичих, бичлэгийн онцлогийг тайлбарлах	- Гротеск төрлийн бичгийн хэв, дүрслэлийн онцлог, ялгаатай танилцах. - Хэв ашиглан Гротеск төрлийн үсгийг бичихдээ хар зураг гаргах, бийрээр зурах, шрифтийн үзэг ашиглах аргуудтай танилцах - Гротеск төрлийн үсгийг хэв ашиглан бичиж турших - Гротеск төрлийн бичлэгийн онцлогийг тайлбарлах	Үзүүлэн, зургийн дэвтэр, балын харандаа, баллуур
7.2в. Таталбар, судалбар зургийн аргаар хүн ба амьтныг дүрслэх	- Таталбар, судалбар зургийн зурах арга ажиллагаа, зургийн хэрэгсэлтэй танилцах - Таталбар, судалбар зургийн ялгааг зураачдын бүтээлүүдийн жишээгээр тайлбарлах - Мал амьтны дүрсийг таталбар, судалбар зургийн аргаар зурж турших	Зургийн дэвтэр, балын харандаа, баллуур, усан будаг, бийр О, Нацагдорж нар. Дүрслэх урлаг, VI-

	<ul style="list-style-type: none"> - Таталбар, судалбар зургийн зурах арга ажиллагааны талаарх ойлголтоо илэрхийлэх - Таталбар, судалбар зургийн аргаар хүн ба амьтныг дүрслэн зурах - Судалбар зургийг усан будгаар зурах аргатай танилцах - Усан будгаар судалбар зургийн аргаар зурах 	VII ангийн сурах бичиг. УБ., 2017 он. Хуудас 98-101
7.2г. Байгалийн өнгө төрх, үзэгдлийг судалбар зургийн аргаар өнгөөр дүрслэх	<ul style="list-style-type: none"> - Байгалийн өнгө төрх, үзэгдлийг зураачдын болон хүүхдийн уран бүтээлийн жишээгээр тайлбарлан ярилцах - Нар жаргах, бороо орох, аянга цахилгаан цахих, шуурга шуурах гэх мэт байгалийн үзэгдлийг судалбар зургийн аргаар өнгөөр (усан будаг, өнгийн харандаа, тосон харандаагаар) зурж дүрслэх - Өөрийн болон бусдынхаа зураг бүтээлийг харьцуулан байгалийн ямар өнгө төрх, үзэгдэл дүрслэгдсэн эсэх талаар харьцуулан ярилцах 	Зургийн дэвтэр, балын харандаа, баллуур, усан будаг, бийр О, Нацагдорж нар. Дүрслэх урлаг, VI-VII ангийн сурах бичиг. УБ., 2017 он. Хуудас 104-111
7.2д. Ардын зураг ба шүтээн зургийн ялгаа, онцлогийг таньж тодорхойлох	<ul style="list-style-type: none"> - Ардын зураг ба шүтээн зургийн зохиомж, өнгө, дүрслэлийн ялгааг тодорхой бүтээлүүд дээр харьцуулалт хийн ярилцах - Монгол зургийн дүрслэлийн онцлог, зураасны төрлүүдийг таних - Ардын зураг ба шүтээн зургийн бүтээлүүдээс судлах онцлог, ялгааг бүтээлийн жишээгээр тайлбарлах 	Үзүүлэн, сурах бичиг О, Нацагдорж нар. Дүрслэх урлаг, VI-VII ангийн сурах бичиг. УБ., 2017 он. Хуудас 120-122, 126
7.2е. Монгол зургийн зурааслах техникүүдийг зураг дүрслэлд ашиглах	<ul style="list-style-type: none"> - Монгол зургийн зурааслах техникүүдийг багшийн зурж дүрслэх явцад ажиглах - Монгол зургийн зурааслах техникүүдийг бийрээр зурж турших, нэршилтэй холбон тайлбарлах - Байгалийн гаралтай хээ угалзыг монгол зургийн аргаар хуулбарлан зурж турших - Монгол зургийн аргаар зурсан бүтээлүүдийн дүрслэлийг ажиглах харьцуулан ярилцах - Монгол зургийн аргаар зурсан бүтээлүүдээс санаа авч сэдэв зураг зурах - Сэдэвт зурагт ашигласан монгол зургийн арга техникүүд, дүрслэлийг тайлбарлах 	Зургийн дэвтэр, балын харандаа, баллуур, усан будаг, бийр О, Нацагдорж нар. Дүрслэх урлаг, VI-VII ангийн сурах бичиг. УБ., 2017 он. Хуудас 123-125

7.3 Соёлын үнэт зүйл

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
7.3а. Зүмбэрлэх болон шуумал хийх аргыг туршин хэрэглэх	<ul style="list-style-type: none"> - Зүмбэрээр чимэглэсэн эртний эдлэл, хэрэглэлийн зургийг ажиглах, өөрт төрсөн сэтгэгдлээ хуваалцах - Зүмбэрээр чимэглэх хийх аргыг судлах, арга технологийг туршиж чимэглэл хийх, өнгө ялган будах - Шуумлын аргаар маск, өндөгөн чимэглэл хийх - Зүмбэр болон шуумлын ялгаа болон хийх арга технологийг талаар тайлбарлах 	Зүмбэрийн материал, цаас, цавуу О, Нацагдорж нар. Дүрслэх урлаг, VI-VII ангийн сурах бичиг. УБ., 2017 он. Хуудас 116-119
7.3б. XIV-XVII зууны үеийн Монголын дүрслэх урлагийн бүтээлийг таньж тодорхойлох	<ul style="list-style-type: none"> - XIV-XVII зууны үеийн Монголын дүрслэх урлагийн бүтээлүүдтэй танилцах - XIV-XVII зууны үеийн Монголын дүрслэх урлагийн бүтээлүүдийн онцлогийг өөрийнхөөрөө тайлбарлах - XIV-XVII зууны үеийн Монголын дүрслэх урлагийн бүтээлүүдийн жишээн дээр тухайн цаг үе, хүмүүсийн ахуй амьдралын талаар таамаглал дэвшүүлэх - Тухайн цаг үеийн түүхэн эх сурвалжийг таамаглалтайгаа 	Зурагт үзүүлэн О, Нацагдорж нар. Дүрслэх урлаг, VI-VII ангийн сурах бичиг. УБ., 2017 он. Хуудас 136-139

	холбон авч үзэх дүгнэлт гаргах -Занабазарын уран бүтээлийн тухай ярилцах, музей үзэх	
7.3в. Дундад зууны болон дэлхийн зарим улс үндэстний дүрслэх урлагийн бүтээлийн онцлогийг таньж тодорхойлох	- Дундад зууны дүрслэх урлагийн бүтээлийн онцлогийг бүтээлийн жишээн дээр тайлбарлах - Энэтхэг, Хятад, Япон, Солонгос, Оросын дүрслэх урлагийн бүтээлд тухайн ард түмний зан заншил, газар нутаг, ёс уламжлал, соёлын ялгааг хэрхэн тусгалаа олсон эсэх талаар ярилцах - Улс үндэстний дүрслэх урлагийн бүтээлийн онцлогийг тодорхой нэг бүтээлийн жишээн дээр тайлбарлах	Зурагт үзүүлэн О, Нацагдорж нар. Дүрслэх урлаг, VI-VII ангийн сурах бичиг. УБ., 2017 он. Хуудас 140-146

НАЙМДУГААР АНГИЙН ДҮРСЛЭХ УРЛАГИЙН СУРАЛЦАХУЙН УДИРДАМЖ

8.1 Урлагийн хэл

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
8.1а. Дулаан, хүйтэн, ойролцоо өнгийн зохицол үүсгэн зохиомжлох, зураг дүрслэх хэрхэн нөлөөлөхийг ашиглах	- Өнгийн зохицол, хүйтэн дулаан өнгийн ялгаа, эрс тэс чанарын тухай эргэн тойронд байгаа эд зүйлс, фото зургийн жишээгээр тайлбарлан ярилцах - Өнгийн хэлбэр дүрс бүхий төрөл бүрийн өнгийн цаас ашиглан өнгийн дулаан, хүйтэн, ойролцоо өнгийн зохицол үүсгэн зохиомжлох туршилтууд хийх - Зохиомжлох туршилттай холбоотой өөрсдийн бодлоо бусаддтайгаа хуваалцах - Төрөл бүрийн хэлбэр дүрсийн зохиомжийг өнгөөр будах - Өнгийн зохиомжийг агуулсан уран бүтээл, өрөө тасалгаа, хувцасны загварын талаар судалж бодит жишээн ярилцах	Зургийн дэвтэр, балын харандаа, баллуур, усан будаг, бийр, өнгийн цаас, хайч Д, Цэдэн-Иш нар. Дүрслэх урлаг, VIII ангийн сурах бичиг. УБ., 2016 он. Хуудас 14-19
8.1б. Цэг, толбо зураасыг хослуулан хүн амьтан эд юмсыг чөлөөт зохиомжоор дүрслэх	- Зураасны хэмнэл, толбоны олон хэмжээс, өнгө дүрслэлтэй хослуулан хийсэн бүтээл болон хавтгайн зохиомжуудтай танилцах - Бүтээлүүд болон хавтгай зохиомжийг ямар аргаар хэрхэн хийсэн талаар ажиглах, тайлбарлах - Хавтгайн зохиомж хийх аргуудыг судалж турших - Цэг, толбо зураасыг хослуулан хийх зохиомжийн санааг гаргах, хийх - Зохиомжийн арга аргачлал, илэрхийллийг тайлбарлах	Үзүүлэн, зургийн дэвтэр, балын харандаа, баллуур Д, Цэдэн-Иш нар. Дүрслэх урлаг, VIII ангийн сурах бичиг. УБ., 2016 он. Хуудас 5-8
8.1в. Юмсын хол, ойр байршил ба биетийн эзэлхүүнийг хоёр ба гурван цэгийн алслалтын аргаар дүрслэн харуулах	- Хоёр ба гурван цэгийн алслалтаар шоо, гудамж, өндөр барилга зурах - Хоёр ба гурван цэгийн байршлаас шалтгаан биетийн хэлбэр дүрс хэрхэн өөрчлөгдөж байгааг ажиглах, төрөл бүрийн эд зүйлсийг хоёр ба гурван цэгийн алслалтын шугаман байгуулалтаар зурсан дүрслэлийн талаар ярилцах, жишээгээр тайлбарлах	Үзүүлэн, зургийн дэвтэр, балын харандаа, баллуур Д, Цэдэн-Иш нар. Дүрслэх урлаг, VIII ангийн сурах бичиг. УБ., 2016 он. Хуудас 26-29
8.1г. Хүүхэд болон том хүнийг зурахдаа хүний биеийн ерөнхий харьцааг дүрслэх аргыг ашиглах	- Хүүхдийн биеийн харьцааг том хүний биеийн харьцаатай харьцуулан ажиглалт хийн ярилцах -Хүүхэд, том хүн балын харандаагаар зурах, таталбар, судалбар хийх (Хүүхэд болон том хүний биеийн хэлбэр, хөдөлгөөн бусдаас ялгарах онцлогийг ажиглан дүрслэх) - Таталбар, судалбар зургийн аргаар хүүхэд болон том хүний ерөнхий харьцааг хэрхэн дүрслэн илэрхийлсэн талаар ярилцах <i>Багшийн анхаарах зүйл: Хүний биеийн ерөнхий хэмжээ,</i>	Үзүүлэн, зургийн дэвтэр, балын харандаа, баллуур Д, Цэдэн-Иш нар. Дүрслэх урлаг, VIII ангийн сурах бичиг. УБ., 2016 он. Хуудас 45

	харьцааг хэрхэн баримжаалан дүрслэх талаар багш сурагчдад зааварчилгаа өгсөн байна.	
--	---	--

8.2 Урлан бүтээх

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
8.2а. Натюрмортын гэрэл,сүүдрийг зурааслах аргаар илэрхийлэх	Энгийн сав суулга төрөл бүрийн материалаас бүрдсэн натюрмортыг балын харандаагаар зурах - Энгийн сав суулга төрөл бүрийн материалаас бүрдсэн натюрмортын хэмжээ харьцааг ажиглах - Натюрмортуудын хэмжээ, харьцааг харьцуулан жиших - Байршил, харьцааг ерөнхийлөн дүрслэх - Натюрмортын байгуулалт хийх, хэлбэрийг гаргах - Гэрэл сүүдрийг зурааслах аргаар ялган зурах - Гүйцэтгэн боловсруулалт хийх	Үзүүлэн, зургийн дэвтэр, балын харандаа, баллуур
8.2б. Антиква үсгийн уран бичлэгийн онцлогийг тайлбарлах	- Антиква төрлийн бичгийн хэв, дүрслэлийн онцлог, ялгаатай танилцах - Хэв ашиглан антиква төрлийн үсгийг бичихдээ хар зураг гаргах, бийрээр зурах, шрифтийн үзэг ашиглах аргуудтай танилцах - Антиква үсгийн уран бичлэгийн онцлогийг тодорхойлох - Уран бичлэг бичих аргаар өөрийн нэрийг бичиж турших - Уран бичлэгийн онцлогийг жишээгээр тайлбарлан ярилцах	Үзүүлэн, зургийн дэвтэр, балын харандаа, баллуур Д, Цэдэн-Иш нар. Дүрслэх урлаг, VIII ангийн сурах бичиг. УБ., 2016 он. Хуудас 73-75
8.2в. Өөрийн бодол төсөөллийг бар зургийн аргаар илэрхийлэх	- Бар зураг түүний төрөл, зурах арга ажиллагааны талаарх мэдээллийг уншиж судлах - Бар зургийн онцлог, арга ажиллагааг жишээн дээр тайлбарлах - Хулдаасан барын аргаар байгаль, амьтан зурах - Хийсэн бүтээлийн жишээн дээр хулдаасан барын аргыг тайлбарлах	Үзүүлэн, зургийн дэвтэр, балын харандаа, баллуур Д, Цэдэн-Иш нар. Дүрслэх урлаг, VIII ангийн сурах бичиг. УБ., 2016 он. Хуудас 48-51
8.2г. Натюрмортын гэрэл,сүүдрийг өнгөөр илэрхийлэх	- Нэг өнгийн дагнаасыг усан будгаар зурж туршилт хийх (Сурах бигийн өгсөн зааврын дагуу туршилтыг хийх) - Хэд хэдэн өнгийн уусалтыг усан будгаар хийж турших - Натюрморт өнгөөр зурсан зураг бүтээлүүийг ажиглах, сэтгэгдлээ хуваалцах - Натюрморт өнгөөр зурсан дарааллыг ажиглах - Энгийн сав суулга төрөл бүрийн материалаас бүрдсэн натюрмортын байгуулалт хийх - Усан будгаар натюрмортын гэрэл, сүүдрийг зурах - Натюрмортын гэрэл,сүүдрийг өнгөөр дүрслэн зурах арга ажиллагааг зурсан зургийнхаа жишээн дээр тайлбарлах	Үзүүлэн, зургийн дэвтэр, балын харандаа, баллуур, усан будаг, бийр Д, Цэдэн-Иш нар. Дүрслэх урлаг, VIII ангийн сурах бичиг. УБ., 2016 он. Хуудас 30-33
8.2д. Монгол зургийн зохиомж, өнгө, арга ажиллагаа уран бүтээлийн жишээн дээр тайлбарлах	- Монгол зургийн зохиомж, өнгө, арга ажиллагааны талаар уншиж судлах - Монгол зургийн аргаар сэдэвт зураг зурах, турших - Зурсан сэдэвт зургийн зохиомж, өнгө, арга ажиллагааг тайлбарлах - Монгол зургийн аргаар зурсан өөрийн болон зураачдын зураг бүтээлийн жишээн дээр зохиомж, өнгө, арга ажиллагааг тайлбарлан ярилцах - Музей, галерей үзэх	Д, Цэдэн-Иш нар. Дүрслэх урлаг, VIII ангийн сурах бичиг. УБ., 2016 он. Хуудас 62-65
8.2е. Монгол зургийн аргаар өгөгдсөн сэдвээр бүтээл хийх	- Монгол зургийн зурааслах техникүүдийг турших, зураасны олон төрлүүдийг бийрээр зурах - Өгөгдсөн сэдвээр монгол зургийн аргаар зурах	Зургийн дэвтэр, балын харандаа, баллуур, гуаш, бийр

	- Сэдэвт зургийн утга санаа, зохиомж, өнгө, зурах араг ажиллагааг тайлбарлан ярилцах	
--	--	--

8.3 Соёлын үнэт зүйл

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
8.3а. Монголын дүрслэх урлагийн төлөөлөгчдийн бүтээлийг таньж тодорхойлох /1921 оноос одоог/	<ul style="list-style-type: none"> - 1921 оноос хойшхи Монголын дүрслэх урлагийн төлөөлөгчдийн зураг бүтээлүүдтэй танилцах - Монголын дүрслэх урлагийн төлөөлөгчдийн бүтээлийн утга санааг, илэрхийлэл, зохиомж, өнгө дүрслэл, арга ажиллагааны онцлог зэргийг бүтээлийн жишээн дээр харьцуулан тайлбарлах - 1921 оноос хойшхи Монголын дүрслэх урлагийн төлөөлөгчдийн зураг бүтээлүүдээс дүрслэх урлагийн олон чиг хандлага хөгжиж ирснийг ойлгож илэрхийлэх - Музей, галерей үзэх 	Зурагт үзүүлэн Д, Цэдэн-Иш нар. Дүрслэх урлаг, VIII ангийн сурах бичиг. УБ., 2016 он. Хуудас 85-94
8.3б. Сэргэн мандалтын үеийн дүрслэх урлагийн зарим бүтээлийг таньж тодорхойлох	<ul style="list-style-type: none"> - Сэргэн мандалтын үеийн дүрслэх урлагийн зарим бүтээлтэй танилцах - Сэргэн мандалтын үеийн дүрслэх урлагийн төлөөлөл болсон бүтээлүүдийг ажиглах, зургийн үйл явдал, дүрслэлийн талаар таамаглал дэвшүүлэх -Зураг бүтээлийн агуулга, утга санааг уншиж судлах, таамаглалтайгаа харьцуулан авч үзэх, дүгнэлт гаргах - Сэргэн мандалтын үеийн дүрслэх урлагийн бүтээлүүдийн нийтлэг болон онцлог шинжийг бүтээлийн жишээн дээр харьцуулан ярилцах - Цахим музей, галерей үзэх - Өөрт төрсөн сэдгэгдлээ илэрхийлэх 	Зурагт үзүүлэн Д, Цэдэн-Иш нар. Дүрслэх урлаг, VIII ангийн сурах бичиг. УБ., 2016 он. Хуудас 20-25
8.3в. Дүрслэх урлагийн зарим чиг хандлагуудыг бүтээлийн жишээн тайлбарлах	<ul style="list-style-type: none"> - Дүрслэх урлагийн нэрт төлөөлөгчдийн бүтээлүүдтэй танилцах тухайн бүтээлийн урсгал чиглэл, дүрслэлийн болон утга агуулгын талаар ярилцах - Цахим музей, галерей үзэх 	Сурах бичиг, үзүүлэн